БАТЛАВ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГА С.ДАВААСҮРЭН

2025 оны 06 дугаар сарын 19

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН ГАДНА ХАШААГ ШИНЭЧЛЭХ МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025 оны 06 дугаар сарын 19 №ТТ- 18 Багануур дүүрэг

1	Үндэслэл	Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 06–ны өдрийн ээлжит VII дугаар хуралдааны 10 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт
2	Байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ	1 дүгээр хороо ЗДТГ-ын баруун талын цэцэрлэгт хүрээлэн
3	Зориулалт, хүчин чадал	1900 метр урт 3м өндөртэй төмөр сараалжин хашаагаар хөл бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн зэргийг хашаална.
4	Одоогийн байдал	Хашаа хуучирч муудсан, цоорч урагдсан, өнгө үзэмжгүй болсон, 420 м бетон хашаа засварлах боломжгүй болсон тул буулгах
5	Захиалагч	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар
6	Санхүүгийн эх үүсвэр	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 172.600.000 (нэг зуун далан хоёр сая зургаан зуун мянган) төгрөг
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно;
8	Төсөл гүйцэтгэх байгууллага	Гадаад дотоод худалдаа эрхлэдэг зөвшөөрөлтэй хуулийн этгээд байна;
9	Ажлын үе шат	2 үе шаттай. Үүнд: I. Техникийн тодорхойлолт боловсруулах II. Ажлын гүйцэтгэл
10	Хийгдэх ажлууд, тавигдах шаардлага	**Цэцэрлэгт хүрээлэнгийн хашаа:** - Төмөр сараалжин хашаа 2,5 м урт 3 м өндөртэй 760 ширхэг хашаа байна. - Хашааны шон 100*100 мм, 3м өндөртэй төмрийн зузаан 2,5мм байна - Хашааны дай 60*40мм, 2,5м урттай 2ш байна төмрийн зузаан 1,5мм-ээс дээш байна. - Хашааны савх 50*30мм, 3м өндөртэй байна төмрийн зузаан 1,5мм-ээс дээш байна. - Төмөр шонтой гадагшаа онгойдог том гоёлын хаалга /6м өргөнтэй 3м өндөртэй/ - 2ш - Явган хүний хаалга 2,5 өндөр 1,5м өргөн 3ш - Цемент 4.25 марктай 3 тонн - Шон бүр малгайвч төмөртэй байна. **Авто замын тусгаарлах хашаа:** - Авто замын тусгаарлах хашаа 110 метр урт 80-100 см өндөртэй угсардаг, төмөр хөлтэй хашаа - Төмрийн зузаан 1,5 мм-ээс багагүй байна - Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах автомат

		Буулгалтын ажил: - 420 метр урт 2 метр өндөртэй бетон болокон хашааг буулгах - Гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт буулгах **Хашаа угсрах ажил:** - Шонгийн нүхийг өрөмдөж ухах, гүн-50 см - Ухсан нүхэнд бетон шонг суулгаж бул чулуугаар хөдөлгөөнгүй болтол сайтар чигжиж В15 ангийн шингэн бетоноор дүүргэнэ. - Металл хашааг үйлдвэрт урьдчилан бэлдэж ирэх, ба талбай дээр угсарч гүйцэтгэнэ. Гагнаасны өндөр 4-5мм, гангийн бат бэх СТ345 - Металл хашааг суурь будаг үндсэн өнгө гэсэн дараалаар будсан байна. - Бэлдсэн төмөр хашааг шонгийн детальд тулгаж гагнана. **Бусад шаардлага:** - Хашаа 2 талдаа 6 метрийн өргөнтэй хаалгатай байх ба гоёлын хаалга байна. - Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах автомат зогсоолын өргөдөг хаалга 1ш - Газар зүйн байрлал хэвгийд тохируулж зарим хашааг налуу хийх шаардлагатай. - Угсралтын ажил гүйцэтгэхэд захиалагчтай зөвшилцөж хийнэ. - Хашааны сараалжин төмрийн хоорондох зай 12см байна. - Буулгалт болон угсралтын зардлыг тухайн төсөвт тусгасан болно.
11	Иж бүрдэл	Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтад заасан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журамд зааны дагуу бичиг баримтыг 4 хувь үйлдэж бүрдүүлж өгнө.
12	Ажил гүйцэтгэхэд ашиглах хууль, норм дүрэм, стандарт	<u>Монгол улсын хуулиуд:</u> - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Хөдөлмөрийн тухай хууль - Барилгын тухай хууль - Бусад холбогдох хууль тогтоомж; <u>Норм, дүрэм, журам, холбогдох стандартууд:</u> - Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ UCS0001-02:2019, UCS 1410B:2022; - Барилгын материалын чанар стандартын ерөнхий шаардлага, баталгаажуулалт UCS1504C:2020;
13	Эдийн засгийн тооцоо	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;
14	Нэмэлт нөхцөл	- Бараа материалын тоо хэмжээнд өөрчлөлт орох тохиолдолд захиалагч байгууллагад заавал

		- Бараа материал болон бусад бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль журам, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэж, нийлүүлнэ. - Хэрэглэгдэх материалууд нь стандартын шаардлагыг бүрэн хангасан байх; - Бараа материал нь урьд өмнө ашиглагдаж байгаагүй, шинэ байна;

ХЯНАСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.МӨНХЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ж.БАТБАЯР